

## БОГТАГ МАЛГАЙН ЧИМЭГЛЭЛҮҮД, ТЭДГЭЭРИЙН БЭЛГЭДЭЛ

Дашнанжидын Сайхансувд

Олон улсын Улаанбаатарын их сургууль, Дизайны тэнхим, Улаанбаатар, Монгол улс  
saikhansuvd.d@ulaanbaatar.edu.mn

**Хураангуй:** Монголын эзэнт гүрний үеийн монгол малгайнуудаас хамгийн өвөрмөц хийц маяг, баялаг чимэглэлтэй нь эхнэр хүний богтаг малгай юм. Уг нийтлэлд археологийн малтлагаар олдсон болон зургийн, бичгийн сурвалжууд дахь XIII-XIV зууны үеийн монгол эмэгтэйн богтаг малгайг харьцуулан судалсны үндсэн дээр судалгааны сэдвийн үндэслэл, олон талт байдлыг тодорхойлох болно. Судалгаанаас үзэхэд, богтаг малгайн чимэглэл нь маш олон янзын хийц хэлбэртэй байсан нь тодорхой байна. Тэдгээр олон янзын чимэглэлүүд нь гоё сайхан харагдах талаасаа гадна бэлгэдлийн нарийн утгыг агуулдаг байв. Түүнчлэн өмсөж буй эзнийхээ зэрэг зиндаа, хөрөнгө чинээ, шашин шүтлэгийг хүртэл илэрхийлдэг байжээ. Эзэнт гүрэн өргөжин тэлэхийн хирээр эзлэн суусан бусад орнуудын соёл, ёс заншил, шашин шүтлэг, эд баялаг зэрэг хүчин зүйлсийн харилцан нөлөөгөөр богтагны чимэглэлийн материал, хэлбэр, ур хийц, утга бэлгэдэл хувьсан өөрчлөгдөж байсан байна.

*Түлхүүр үгс:* өд, оройн чимэг, сувд, цог чимэг, ом үсэг

## DECORATIONS OF THE BOQTA AND THEIR SYMBOLIC MEANINGS

Saikhansuvd Dashnanjid

Department of Design, International University of Ulaanbaatar, Ulaanbaatar, Mongolia  
saikhansuvd.d@ulaanbaatar.edu.mn

**Summary:** The hat, which has the most unique design and rich decoration Among the Mongolian hats from the time of the Mongol Empire is the wife's hat Boqta. The article considers boqta hats of Mongol women in the 13th-14th centuries, comparing the written and pictorial sources and the actual finds found in archaeological excavations to determine the validity and diversity of the research subject.

According to research it is clear that the decoration of boqta hats was too many kinds. In addition to being beautiful, these various decorations had a deep symbolic meaning. Also, it represented the status of social class, wealth, and religion of the wearer. With the expansion of the empire, the decoration of the boqta evolved and the craftsmanship became more elaborate due to the mutual influence of the culture, customs, religion,



and wealth of the other countries occupied by empire. Therefore, on the other hand, the decoration of the boqta hat indicated the extent and reach of the Mongol empire.

*Keywords: feathers, decoration on top, pearl, tsog decoration, Om syllable*

## Оршил

Богтаг малгайн талаар дотоод гадаадын эрдэмтэд багагүй судалжээ. Тухайлбал, С.Дулам (2009), Д.Баяр (2002), Х.Нямбуу (2002), Марта Бойер (1995), Илдико Ока (2015) нарын судалгаануудыг онцлон дурдаж болно.

Гэхдээ дээрх судалгаанууд уг малгайн талаарх дагнасан судалгаа биш юм. “Монгол эхнэрийн богтаг малгай” сэдвээр З.Батсайхан (1995) эрдэм шинжилгээний өгүүлэл, У.Эрдэнэбат (2006) нэг сэдэвт зохиол бичсэн нь энэ сэдвээр дагнан судалсан судалгааны ажлууд юм. Дээрх судалгааны ажлууд нь ихэвчлэн малгайн гарал үүсэл, хэлбэр хийц, бэлгэдэл, ёс горим талаас нь судалсан байх бөгөөд малгайн чимэглэлүүдийн талаар нарийвчлан судлаагүй байна. Сурвалж бичгийн мэдээнүүдэд ч хэлбэр, хийц, хэмжээ, хэрхэн үйлддэг байсан талаас нь дүрсэлж бичсэн нь олон байдаг боловч орой дээрх өдөн чимэглэлийн талаар дурдсаныг эс тооцвол бусад чимэглэлийн талаар мөн л төдийлөн нарийн дүрслэн бичээгүй байдаг. Харин богтаг малгайн чимэглэлийн талаар У.Эрдэнэбат (2010) монгол нутгаас археологийн малтлагаар илэрсэн богтаг малгайн олдворууд дээр үндэслэн, тэдгээрийн хэлбэр хэмжээ, хийц маяг, малгайн хаана байрлуулдаг байсан талаар судалгааны ажил нийтлүүлжээ.

Эрт дээр цагаас монголчууд хувцаснаас малгайг ихэд хүндэтгэн дээдэлж байсны учир малгайн хэлбэр хийц, өнгө, чимэглэлд бэлгэдлийн утга агуулгыг чухалчлан үздэг байсан билээ. Тиймээс бид энэхүү судалгааны ажлаараа өмнөх судлаачдын судалгаанд харьцангуй бага судлагдсан богтаг малгайн зөвхөн чимэглэлүүд, тэдгээр нь зөвхөн гоё сайхан харагдах талаасаа илүүтэйгээр нарийн утга бэлгэдлийг агуулдаг байсан талаар дэлгэрүүлэн судлах болно. Судалгааг хийхдээ судалгааны эх хэрэглэгдэхүүн болох XIII-XIV зууны үед хамаарах түүхэн сурвалж бичгүүд, Монголоор аялсан жуулчин болон элч нарын тэмдэглэлүүд, богтаг малгайг дүрсэлсэн Юань гүрний үеийн уран зургууд, Ил хаант улсын үеийн Персийн миниатюр зургууд, гадны болон дотоодын музей, цуглуулгад хадгалагдаж буй археологийн малтлагаар илрэн гарсан богтаг малгайн олдворууд дээр үндэслэн, тэдгээрийг харьцуулан судаллаа.

XIII-XIV зууны монгол эмэгтэй хүний гол малгай бол эхнэр хүний богтаг малгай юм. Түүхэн баримтуудыг судлан үзвэл, монгол эмэгтэйчүүд эрт дээр үеэс буюу бидэнд мэдэгдэж буйгаар Хүннүгийн үеэс өндөр гозгор малгай өмсдөг байжээ. Тэр үеэс хэлбэр хийц хувьсан өөрчлөгдсөөр XIII-XIV зууны үеийн богтаг малгай нь үндсэн хэлбэрээ X зууны үеэс олж авсан бололтой. Таван төрийн /907-960/ үед бүтээгдсэн “Цөлд яваа жингийн цуваа” зурагт богтаг малгайтай хоёр эхнэрийг зурсан байдаг. Энэ зураг бол одоогоор бидэнд он цаг нь тодорхой мэдэгдэж буй богтаг малгай дүрсэлсэн уран зургийн эртний дурсгал болно (Сувд, Эрдэнэбат, Саруул, 2015, 28). XIII-XIV зууны үеийн уран зургуудад богтаг малгай

олонтоо дүрслэгдсэний дээр археологийн матлагаар илрэн гарсаар байна. Эдгээр эх хэрэглэгдэхүүнээс богтаг малгай болон тэдгээрийн чимэглэлүүд нь олон янзын хэлбэр хийцтэй байсан бөгөөд цаг хугацааны явцад хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг харж болно. Богтаг малгай нь толгойд өмсөх хэсэг буюу доод хэсэг, орой хэсэг рүүтээ өргөссөн бортого буюу дээд хэсэг гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Доод хэсэг нь толгойд өмсөх хэсэг, ар шилэвч, түүнийг даруулж боосон алчуур, бүч гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Харин дээд хэсэг нь дээшээ үзүүр лүгээ дөрвөлжилж өргөссөн бортого хэлбэртэй хөндий хоолой юм. Эдгээр хэсгүүд тус бүр өөр өөрийн онцлог утга бэлгэдэл бүхий чимэглэлүүдтэй байв. Малгайн дээрээсээ доош нь дарааллаар хэсэг тус бүрийн чимэглэлүүдийг нарийвчлан авч үзье.

### Богтагны дээд хэсгийн чимэглэл

#### Оройн чимэг

Эрэгтэй, эмэгтэй гэлтгүй XIII-XIV зууны монголчуудын малгайн оройн гол чимэглэл нь өд байв. Арменийн төрийн зүтгэлтэн, түүхч Хетум Патмич (2006) “Дорнын түүхийн цэцэг” зохиолын 5-р бүлэгт татарууд яагаад толгойнодоо өд зүүх болсон тухай өгүүлэхдээ: “Шөнө болоход Чингис хаан нуугдаж байсан газраа орхиж, тэдний хүмүүс дээр хүрч ирээд; өөрт нь юу тохиолдсон талаар хэлжээ. Тэрээр хэлэхдээ, түүний нуугдаж байсан газар бутан дээр сууж байсан шувуудын ачаар дайснууд түүнийг тэнд хайсангүй явсан гэж хэлэв. Тэр цагаас хойш татарууд бурханд талархаж, шувууд түүнийг аварсан ачийг санаж хүндэтгэн, ноёд шувууны өд толгой дээрээ зүүх болжээ. Энэхүү үлгэрийн дагуу тэд толгойн өмсгөлийг гоёл чимэглэлийн зориулалтаар биш, харин хүндэтгэл, дурсамжийн бэлгэдэл болгон өдөөр чимэглэх болсон” гэжээ (Ayrat G. Sitdikov, Lyudmila E. Maklasova, 2017, 355). Энд өгүүлж буй түүх нь Монголын нууц товчооны 80-85-р зүйлд өгүүлэх Тэмүүжин тайчуудаас зугтаж шугуйд нуугдаж байгаад дараа нь Сорхон шарын гэрт ирдэг тухай бололтой. Тэмүүжин Сорхон шарын гэрт ирэхэд, Сорхон шар түүнд хандан: “Эх дүү нараа эрэн од хэмээн хэлсэн бус уу, би? Яахан ирэв, чи?” хэмээхэд Чимбай, Чулуун хоёр хөвүүн нь өгүүлрүүн: “Шувуухайг туримтай бутанд хоргоовоос, бут түүнийг авардаг. Эдүгээ бидэнд хүрч ирснийг яахан тийн хэлнэ, та?” хэмээн эцгийнхээ үгийг үл таалан, бугууг нь цуцалж авч, галд түлээд, гэрийн ардах унгастай тэргэнд нууж...” (Бира, Дашцэдэн, Сумьяабаатар ба бус., 2011, 25) хэмээдэг хэсгээс үүдэж ийнхүү тайлбарлажээ. Хетум Патмич “Шувуухайг туримтай бутанд хоргоовоос, бут түүнийг авардаг” гэсэн зүйрлэж хэлсэн үгийг шувуудын ачаар дайснууд түүнийг тэнд хайсангүй явсан гэж андуу бодсон бололтой. Гэвч түүний монголчууд шувууг хүндэтгэн дээдэлж, өдийг нь малгайн дээрээ хатгадаг гэсэн санаа нь чухал юм. Нүүдэлчдийн дунд тэнгэрийн амьтан учир шувууг толгой дээрээ дээдлэн тахих явдал нэн эртнээс байсан байна. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Алтайн уулны Олон гүүрний гол хэмээх газраас МЭӨ VI-II зууны үед хамаарах олон тооны дурсгалын зүйл илрүүлсэн байдгийн дотор шувууны толгойн дүрст модон чимэглэлээр оройг нь чимсэн эсгий малгай гарчээ. Мөн ӨМӨЗО-ы Ар Цайдамаас олдсон Хүннүгийн Шаньюгийн орой дээрээ шонхор шувууны дүр бүхий алтан титэм, Түрэгийн хаан Билгэ, Куль-тегин нарын урдаа шувууны дүртэй титэм, Хятаны язгууртнуудын титмүүд зэрэг олон жишээ үүнийг баталж байна.

XIII-XIV зууны монголчууд малгай дээрээ шувууны өд хатгадаг нь ч тэргүүн дээрээ шувууг залах эртний бэлгэдлийн улбаа үргэлжилсээр буйг харуулж байна. Богтаг малгайн өдөн чимэглэлийн талаар бичгийн сурвалжуудад: “Эмэгтэйчүүд нь богтаг хэмээх толгойн боолт зүүж гоёно. Энэ нь модны холтос буюу эсвэл өөр ямар нэгэн хөнгөн эдээр хийж торгоор чимсэн тэвэр хэртэй бүдүүн, тохой илүү урт бортого болно. Түүний хөвөө нь дөрвөлжин агаад үзүүрт нь шувууны өд буюу ургамлын иш цухуйлган уяж, дээр нь тогосын өд хатган нугасны өд, эрдэнийн чулуугаар чимэглэнэ (Рубрук, 1988, 114). Тэд толгой дээрээ дугуй богтаг хэмээх нэгэн зүйл малгай тавина. Энэ малгайг уртаашаа нэгэн тохой орчим саваа буюу холтсоор зүйж хийх агаад дээшээ дөрвөлжилсэн, доошоо өргөсөх бөгөөд оройд нь нарийхан алт мөнгөн буюу модон савх, эсвэл өд хатгана” (Карпини, 1988, 14), Хэйда шилюз-д: “Сюй Тин би гу-гу малгай хийх аргыг үзэв. Малгайн голыг будсан модоор хийх бөгөөд түүнийг улаан өнгийн торгоор юмуу эсвэл алтадсан торгоор бүрж, орой дээр нь уд модны мөчир эсвэл дөрвөөс таван тохой өндөр нахилзуур шиг давтсан төмөр хатгаж, түүнийгээ хөх эсгийгээр орооно. Эрхэм хүмүүс манай улсын оюу цэцэг буюу таван өнгийн торгоор чимэглэж, түүнийг намилзуулан хийсгэмүй. Доорд хүмүүс бол гургуулын өдийг хэрэглэнэ” (Баясах, 2005, 84), зохиолч Янь Юнь-фугийн Луань-цзин цза-юанд байдаг Сян-чэ ци баод бичсэнээр “Гу-гу өмссөн эмэгтэйчүүд битүү тэргээр зорчихдоо малгайнаасаа нэг чи орчим өдийг нь сугалан авч, өөдөөс харж суудаг шивэгчин хүүхнүүддээ бариулдаг”, Ху-Цзиний Нань-сюнь-дянь ту-сян каод хоёрдугаар хэсэг; Юн-лэда-дань шастирт “...Орой дээр нь хулсан гуурс тогтоох чагт гаргаж гургуулын өд мэтийг тогтоож бэхлэнэ. Гу-гу малгайн ард талд багц өд тогтоож бэхлэх бөгөөд тэдгээрийг өөр өөр өнгөөр алаглуулан буддаг учир /эмэгтэйчүүд морь унаж давхих үед дэлгэсэн дэвүүр мэт харагдана” (Мункуев, 2014, 66-67) гэх мэтээр дурдсан байна. Өдийг мөн богтаг малгайн дөрвөлжилсэн оройн ирмэгээр цухуйлган тогтоодог байсныг ч дурдсан байдаг. Хэдийгээр Юань улсын хатдын хөрөгт орой дээрх өдтэй хэсэг нь тайрагдсан ч ирмэгээр цухуйлгаж тогтоосон улаан шаргал гоёмсог өднүүд тодорхой дүрслэгдсэн байдаг. Рубрукийн тэмдэглэлд малгайн энэ хэсэгт мөн ургамлын иш тогтоон гоёдог байсныг бас дурдсан байна. Сурвалж бичгүүдэд малгайн орой дээр өд хатгана гэж олонтоо дурдсан байгаа ч Сюй Тины тэмдэглэлд уд модны мөчир эсвэл тохой өндөр нахилзуур шиг давтсан төмөр хатгаж, түүнийгээ хөх эсгийгээр ороодог, эрхэм хүмүүс оюу цэцэг буюу таван өнгийн торгоор чимэглэж, түүнийг намилзуулан хийсгэдэг тухай дурдсан байгаагаас үзвэл малгайн орой дээр өднөөс гадна модны мөчир, цэцэг, ургамал эсвэл давтсан төмрийг элдэв хэлбэрт оруулан, гадуур нь эсгийгээр ороож чимэглэл хийх, торго хийсгэх зэргээр олон янзаар чимэглэдэг байсан байна. Үүнийг магадлахад нэлээд дөхөм байж болох дүрслэлүүд Персийн миниатюр зургуудад бий. Персийн миниатюр зургуудад богтагны орой дээрх зүйлсийг нэлээд олон янзаар дүрсэлжээ. Эдгээр зургуудаас он цагийн хувьд яг Ил хаант улсын үед зурагдсан гэж үздэг Берлин дэх Дийц цомгийн зургуудад хатдын богтагны оройн чимэглэл шууд тогос юм уу гургуулын өд гэхэд эргэлзээтэй, гадуураа хар, голдоо улаан, бас ч үгүй нэлээд томхон хэмжээтэй дугариг зүйл байх бөгөөд малгайн орой дээр нэгийг, оройн ирмэгээр нэгийг тус бүр хатгажээ. Зарим зурагт тэдгээрийн хоорондуур сувд бололтой бөөрөнхий цагаан зүйл сүвлэж

чимэглэсэн харагдана (*Зураг 1*). Өдийг ерөнхийлөн зурсан байлаа гэж үзэхэд бусад эрэгтэй хүмүүс болон зарц шивэгчин нарын малгайн өдийг танигдахуйц зурснаас үзвэл ерөнхийлөн зурсан гэж үзэмгүй.

Гэтэл Парисын номын сан дахь зургуудад энэхүү дүгрэг чимэглэлийн ирмэг нь арзгар байх ба түүний голоор нь ургамлын иш эсвэл өдийг сүвлэсэн байдлаар гэхдээ энэ чимэглэл нь богтагны орой хэсгийн ирмэг дээр байхгүй, зөвхөн орой дээр голдоо ганц байгаагаар дүрсэлжээ (*Зураг 2*). Дээрх хоёр сурвалжийн зургуудад байгаа дугариг зүйлийг аль алиныг нь өнгө болоод хэлбэрийн хувьд өд гэхэд эргэлзээтэй байна. Миний бодоход, энэ нь Сюй Тины тэмдэглэлд бичсэнтэй ойролцоо давтсан төмөр эсвэл үйс, мод зэрэг биетэй материалаар дугуй хэлбэр дүрс гарган, түүнийгээ гадуур нь будсан эсгий, бөс торго, ангийн үс зэргээр бүрж хийсэн зүйл бололтой. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Баянголын амны 4-р булшнаас хүрлийг нарийн цувьж түүнийгээ хуйлж модны хэлбэр гарган хийсэн уран гоёмсог хийцтэй богтагны оройн чимэг гарсан нь дээрх таамаглалыг батлах үндэслэл болж байна. Харин эдгээрийг тогтоох нарийн иш нь өдний гуурс, алт, мөнгө зэрэг төмөрлөг, хулсан саваа, савхан мод зэрэг байсан бололтой. Археологийн олдвороор богтагны орой дээр чимэглэл хатгах суурь хэд хэдэн удаа гарсан бөгөөд тэдгээрийн заримд тодруулбал, Гозгор толгойн булшнаас гарсан сууринд савхан мод зоож байсан ул мөр олдсон бол Нартын хадны оршуулгаас нэг талд нь ховил зорж хийсэн саваа мод суурийн хамт гарчээ (Эрдэнэбат, 2014, 350), (Эрдэнэбат, Хүрэлсүх, 2007, 336).

Өөр нэгэн сонирхол татахуйц зураг нь Парисын номын сан дахь Ордны найрыг үзүүлсэн нэгэн зурагт Докуз хатны зүүн талд суух улаан цоохор дээлтэй хатны богтагны орой дээр зургаан дэлбээтэй цэцэг хатгасан байхыг маш тодорхой дүрсэлсэн байна. Гэхдээ энэ цэцэг нь малгайг хулдсан торготой ижил өнгөтэйгөөс гадна хүнийхээ биеийн хэмжээтэй харьцуулбал бодит цэцгээс том хэмжээтэй байгаа тул жинхэнэ цэцэг биш, биетэй материалаар цэцгийн хэлбэр гаргаж хийгээд, гадуур нь торгоор өнгөлж бүрсэн чимэглэл гэж үзүүштэй (*Зураг 3*). Мөн Солонгосын судлаач Чо О Сунгийн судалгааны ажилд нийтлүүлсэн зургийн дөрөв дэх зурагт богтагны орой дээр нарийн ишний дунд хэсэгт цэцэг, түүнээс дээш тариан түрүү мэт урт чимэглэл хатгасан байдлаар дүрсэлсэн байдаг (*Зураг 4*).

Энэ бүгдээс үзвэл богтагны орой дээр дан ганц өд хатгадаггүй, өд, ургамал эсвэл янз бүрийн материалаар цэцэг, навч, элдэв дүрс, хээ угалз гарган хийсэн уран гоёмсог хэлбэртэй чимэглэлийг тогтоон гоёдог байжээ. Бас эдгээр чимэглэлийн нарийн иш, саваа мод эсвэл өдний гуурсанд сувс, сувд, эрдэнийн чулуу сүвлэх зэргээр гоёдог байсан нь Дийц цомгийн нэлээд хэдэн зургуудаас харагддаг. Харин богтагны орой дээрх өдийг хамгийн тодорхой танигдахуйц дүрсэлсэн зураг нь Юань гүрний үед хамаарах “Ямандагийн мандал” торгон нэхмэл зураг байна. Өмнө дурдсан Баянголын амны булшнаас гарсан шиг богтагны оройн чимэглэлийн өвөрмөц содон хэлбэр хийцтэй, хадгалалт харьцангуй сайн даах металл, мод зэргээр хийсэн оройн чимэглэл дахин өөр булшнаас гарч ирж болох ч хурдан үжирч алга болох өд, ургамал зэргийг нотлох баримт археологийн олдвороор гарч ирэх нь бараг боломжгүй юм. Тиймээс бид зургийн болон археологийн сурвалжуудаас л харьцуулан судлахаас өөр аргагүй. Ямартаа ч малгайн хамгийн орой дээр байдаг

учир оройн чимэглэл бэлгэдлийн нарийн утгыг агуулдаг нь дамжиггүй. Өд нь дээр дурдсанаар шувууг дээдлэх нүүдэлчдийн шүтлэгтэй холбоотой бол ургамлын зүйл нь үр шимийн болон дэлгэрэн мандахуйн бэлгэдэл болох бөгөөд монголчуудын байгаль дэлхийдээ сүсэглэх тотем шүтлэгийн улбаа билээ. Харин Дийц цомгийн зургуудад дүрслэгдсэн тэрхүү дугариг зүйл бол нар сарыг бэлгэдсэн бэлгэдэл байж болзошгүй юм. С.Дулам орой дээрээ сампинтай монгол шовгор малгайн хэлбэр хийцийн талаарх Автай сайн хан, Өндөр гэгээн Занабазар нартай холбоотой нэгэн домог дахь өгүүлэмжийг түүнээс эртнийх, тухайн малгай нь Сүмбэр уулын оройд мандах наран титэмлэн байгааг дүрслэн, малгайн оройд “бат найман зангилаа” хэмээх зангидмал улаан залаа хадаж, наран сацрал, галын гэрлийг төлөөлүүлж байжээ. Буриад малгайн оройд үүний оронд нарыг төлөөлсөн “гэвэг” хэмээх улаан шар товх суулгаж, улаан утсан сацаг унжуулдаг нь чухам нарны сацралыг дуурайлгасан хэрэг хэмээн үзжээ (Дулам, 2009, 109). Мөн тэрээр мандах төрийн малгай. Малгай бол монгол төрийн ёст хувцасны тэргүүн мөн. Хүний биеийг толгой тэргүүлдэг шиг хувцасны тэргүүн нь малгай болдог. Монгол хүний гурван ертөнцийн тухай үзэл төсөөллийн ёсоор хүний тэргүүн бол дээд тив, тэнгэрийн сүнсний орон болохоор түүнд өмсдөг хувцасны төлөөлөл малгай нь мөн л дээд ертөнцийг төлөөлсөн наран, сарны дүрс мэтчилэн элдэв чимэгтэй байдаг. Тийм ч болохоор монгол туульсд нар сар хоёрыг хамтаар ургуулсан манлай цагаан дуулга гэхчлэн гардаг (Дулам, 2009, 101) билээ гэсэн байна.

Хэдийгээр дээрх таамаглалыг нотлох нар сарны дүрсийг бэлгэдэн хийсэн оройд хатгах богтаг малгайн чимэглэл археологийн олдвороор гарч ирээгүй байгаа хэдий ч нар сарны дүрстэй малгайн өөр хэсгийн чимэглэлүүд археологийн олдвороор нэг биш удаа гарчээ. Нар сарны дүрстэй богтаг малгайн цог чимэг Дархан-Уул аймгийн Хонгор сумын Буурал уулын булшнаас (Нандин-Эрдэнэ, Амарболд, 2022, 150), Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хориг уулнаас гарсан байдаг. Нүүдэлчин монгол аймгуудын дундаас Хүннүгийн болон Эзэнт гүрний үеийн эд өлгийн зүйлүүдээс нар сарны дүрслэлтэй зүйлс олддог. Харин очирт хөлгөний Бурхны шашинд нар сар нь хамгийн чухал од гарагийн тэмдэг болдог. Алтан улаан нар билиг чанарын оюун билгийг төлөөлдөг бол мөнгөн цагаан сар арга чанарын мэргэн арга, нигүүлсэхүй сэтгэлийг төлөөлнө (Нандин-Эрдэнэ, Амарболд, 2022, 150). Эдүгээ ч Торгуудууд тоорцогны урд талд зэндмэнэ хэмээгч өглөг буяныг хураагч, хүссэн бүхнийг бүтээгч норво эрдэнийг мөнгөөр үйлдэн хадаж, түүний дор саран нэрт зоосон хээг урладаг. Зоосон хээг Торгуудууд нар, сар хэмээдэг нь уг хээний дүрсийг алиман сартай зүйрлүүлэн магнай дээрээ залж, энэ саран эрдэнээ мандуулан гэрэлтүүлж явдаг ажээ (Нямбуу, 1991, 19). Эндээс үзвэл; дээр дурдсан Дийц цомгийн зургууд дахь богтагны оройд хатгасан дугариг зүйл нар сарны дүрс байж болох магадлал их байгаагийн дээр нар сарны дүрсээр малгайгаа чимэх бэлгэдлийн улбаа хожмын монголчуудын хувцсанд ч байсаар байна.

#### Дээд талын ирмэгийн чимэглэл

Өмнө дурдсанаар богтаг малгайн дээшээ дөрвөлжилсөн оройн ирмэгээр өд, ургамлын иш зэргийг хавчуулан чимэглэдэг байв. Түүнээс гадна энэ хэсгийг сувдаар хэлхэж чимэглэх явдал түгээмэл байжээ. Юань гүрний хатдын хөрөгт сүйхэлжин юм уу цэцгэн хэлбэр гарган, сувд хэлхэж чимэглэсэн нь тодорхой

дүрслэгдсэн байх бөгөөд яг ийм чимэглэлтэй богтаг Эрмитажийн музейд бий. Мөн Персийн миниатюр зургуудад богтагны энэ хэсгийг өмнө дурдсанчлан дугариг чимэглэл, сувд, өд гэх мэт олон янзаар чимсэн нь харагдаж байна. Хаан хатан хоёрыг ярилцаж суугаа Дийц цомгийн нэгэн зурагт хатны өмссөн малгайн орой хэсгийн ирмэгийн чимэглэл нь эдгээр зүйлсийг цөмийг нь хамтатган чимэглэжээ. Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойн 1-р булшнаас алтан утсаар сүлжиж хийсэн маш гоёмсог таван дэлбээтэй жижиг цэцгэн чимэглэл хоёр ширхэг гарсныг богтаг малгайн орой хэсгийн дээд ирмэгээр чимэглэж байсан хэмээн үзжээ.

### Нүүрэн талын чимэглэл

Богтагны нүүрэн тал хамгийн олон янзын хэлбэр хийц, төрөл бүхий чимэглэлтэй хэсэг нь юм. Малгайн нүүрэн талд зэс, хүрэл, мөнгө, алт, эрдэнийн чулуу, үйс, торго, даавуу, мод зэргээр хийсэн цэцэг навч, угалз, элдэв-очир, “ом” үсэг зэрэг олон янзын хээ дүрслэлтэй галын сор, цэцгэн, навчин, дугариг, бортого хэлбэртэй цог чимэг, чимэглэлүүдийг хадаж тогтоодог байв. Мөн нүүрэн талыг галын дөл, цэцэг, ургамлын хэлбэр гарган сувд хэлхэж хадах, хатгамлаар оёх, уяагаар зангидах гэх мэт маш олон янзаар чимэглэдэг байжээ.

Персийн миниатюр зураг, Юань улсын хатдын хөрөг зургууд гэх мэт богтаг малгайг дүрсэлсэн зургийн сурвалжууд олон байгаа ч чимэглэлийн талаар бүрэн гүйцэт мэдээллийг бидэнд өгч чадахгүй байна. Юань улсын хөрөг зургуудын малгайн оройн чимэглэл дүрсэлсэн хэсэг нь тайрагдсан, бусад чимэглэлүүд нь бүх зургуудынх ерөнхийдөө төстэй, тэдгээрт археологийн олдвороос гарсан титэм, дугариг, зангилаа, үсэгтэй, нар сартай гэх мэт өөр олон төрлийн чимэглэлүүдийг дүрслээгүй зэрэг дутагдалтай талтай бол Персийн миниатюр зургууд нь уран зохиол, дүрслэх урлагийн уулзвар дээр байрладаг тул зураачид зурсан объекттойгоо жинхэнэ ижил төстэй байдлыг эрэлхийлээгүй, нөгөө талаар жижиг орон зайд олон дүрийг багтаан зурсан тул малгайн ерөнхий хэлбэр хийц танигдахаас биш хувцасны чимэглэл мэтийн маш жижиг харагдах деталиудыг нарийвчлан дүрслэх боломж хязгаарлагдмал юм. Гэсэн хэдий ч Юань улсын хатдын хөрөг зургууд нь бидэнд байгаа богтагны чимэглэлийг хамгийн тодорхой дүрсэлсэн зургууд юм. Эдгээр зургуудын богтагны нүүрэн талд дээд хэсэгт нэг цог чимэг, түүний доор хөндлөн хадсан гонзгой чимэглэл, толгойн зулай хэсэгт нэг цог чимэг, нийт гурван чимэглэл дүрсэлжээ. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Бурхан толгойн 3-р булшнаас гарсан малгайн оройн хэсгийн нүүрэн талд 4,8 см x 4 см хэмжээтэй, зууван хэлбэртэй үйсийг шар торгоор гадарлаж дээр нь олон жижиг цагаан шилэн сувснуудыг хүрэн торгон утсаар хэлхэн хадаж, галын дөл хэлбэр оруулан малгайг чимэглэж байсан нь Юань гүрний эдгээр хатдын зурагт дүрсэлсэн дээд талын цог чимэглэлтэй яг ижил байна (Эрдэнэбат, 2010, 84).

Энэ чимэглэлийн доод талдалтандээр сувд, бадмаараг, оюучулуунууд шигтгэсэн гонзгой хэлбэртэй чимэглэлүүдийг хадаж тогтоожээ. Ийм гонзгой хэлбэртэй, хоёр үзүүрийг алтаар бөгжилсөн оюу чимэглэл Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойн булшнаас гарсан нь одоо Чингис хаан музейд хадгалагдаж байна. Ийм гонзгой хэлбэртэй чимэглэлийг богтаг малгайн яг энэ хэсэгт байрлуулдаг нь тогтсон дэг жаяг байсан нь бодит олдвор болон зургийн сурвалжуудаас тодорхой

харагддаг. Энэ чимэглэл нь зураг дээрх шиг хийцтэйгээс гадна чулуу, алт, мөнгө, хүрэл, гууль, зэсээр хийсэн цул болон дотроо хөндий хонгио байна. Тухайлбал, ӨМӨЗО-ны Улаанхад сумын Жондигоу гэдэг газраас малтсан булшнаас хонгио хүрэл чимэглэлүүд (Эрдэнэбат, 2006, 109) гарсан бол манай орны нутгаас Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хориг уулнаас хоёр ширхэг хүрэл хонгио, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Их Оорцог хэмээх газраас усан биндэрьяа чулуугаар засаж хийсэн, цул нэг, элдэв-очир хээтэй хүрэл хонгио нэг, Баянхонгор аймгийн Гозгор толгойн оршуулгаас мөн элдэв-очирын дүрстэй хонгио нэг ширхэг тус тус олдсон нь мөн Чингис хаан музейд хадгалагдаж байна. Мөн ОХУ-ын Эрмитажийн цуглуулгад байгаа богтаг малгайнд ийм хөндий бортого чимэглэл бий. Судрын чуулганы зургуудад ийм бортого хэлбэртэй хонгиог уяагаар жишүү уяж тогтоосон байхыг олонтоо дүрсэлжээ. Энэхүү бортого хэлбэртэй чимэглэлийг малгайн ард бас тогтоодог байжээ. Биетээр олдсон бортого хэлбэрийн чимэглэлийн нэлээд олон дээр нь элдэв-очир хээг дүрсэлсэн байгаа нь Юань гүрний үед буддын шашин төрийн шашин болсонтой холбоотой юм. Энэ үеэс богтагны чимэглэлд буддын шашны утга агуулга бүхий бичиг, дүрс хээ тодруулбал, элдэв-очир, “ом” үсгийг урлах нь нэлээд түгээмэл болжээ. Тухайлбал, ОХУ-ын Эрмитажийн музейд буй богтаг малгайн дугуй алтан цог чимэг дээр элдэв-очир хээг урлаж голын нүдэнд нь оюу шигтгэжээ. Мөн археологийн олдвороор Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Гозгор толгойн оршуулгаас элдэв-очир хээтэй хүрэл хонгио, “ом” үсэгтэй дугуй хүрэл чимэглэл, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хориг уулын булшнаас дөрвөн дэлбээтэй цэцгийн голд нь “ом” үсэгтэй хүрэл чимэглэл, элдэв-очир хээтэй хүрэл хонгио, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Бургалтай голын хөндийн 3,4-р булш, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Хананбор толгойн 1-р булш, Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаантолгой хэмээх газруудаас тус тус “ом” үсэгтэй зэс хөөмөл, ӨМӨЗО-ны Улаанхад сумын Жондигоугаас ланз үсэгтэй дугуй зэс чимэглэл (Эрдэнэбат, 2006, 109) гарсан байдаг.

Богтагны зарим хөндлөн хонгио чимэглэлийг чухам яагаад хөндий урлаж байсан нь бас сонирхол татууштай. Нимгэн давтсан төмөрлөгийг хуйлж хоёр талыг нь таглан гагнаж хийснээс үзвэл дотор нь хоосонгүй, тодруулбал, үг үсэг бичиж хийдэг байсан бололтой. Буддын шашны ёсонд хүрд, жанцан зэрэг хөндий бортого хэлбэртэй зүйлд маанийн үсэг хуйлж хийдэгтэй адил юм (Сайхансүвд, 2018, 230). Эрмитажид буй богтагны ийм чимэглэл дотроос нунтаг зүйл гарсан бөгөөд тус малгайнд тайлбар хийсэн судлаач Ш.Баатар түүнийг Жанрайсэг бурхны зүрхэн тарни гэж үзжээ. “Ом” үсгийг мөн богтагыг бүрсэн бүрээсэн дээр бичдэг байсан нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Ёдортын хадны оршуулгаас гарсан (Хүрэлсүх, Амгалантөгс, Фрохлич, 2011, 238).

Түүнчлэн ОХУ-ын Эрмитажийн цуглуулгын богтагны үйсэн хүрээ болон торгоны завсар дахь цаасан дээр уйгуржин монгол бичгээр Ум Аа Хум, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Бурхан толгойн 4-р булш, Баян-Өлгий аймгийн Буянт сумын Хөх эргийн хадны оршуулгаас гарсан богтаг малгайг “урт нас”, “аз буян” гэх утгатай нангиад дүрс үсгийг алтан утсаар нэхсэн хээтэй, нимгэн торгоор бүрсэн байжээ (Эрдэнэбат, 2010, 83). “Ом” үсэг нь бурхны шашинд тарнийн тэргүүн үсэг бөгөөд бурхан багшийн бие, хэл, сэтгэлийн бэлгэдэл болдог. Очир хээ нь бурхны



шашинтны баг бэхийн бэлгэ тэмдэг болдог (Бат-Ирээдүй, Арьяасүрэн, 1999, 488). Очир хээ нь муу муухай, хорон бүхнийг даран сөнөөх хэдий ч өөрөө хэзээ ч үл сөнөөгдөгч баг бэх, эрч хүч, төгс чадлын бэлгэ тэмдэг юм. Эдгээрээс үзвэл богтаг малгайн зарим чимэглэл өмсөж буй эзнийхээ шашин шүтлэгийг илэрхийлж байна.

Одоогийн байдлаар биет байдлаар олдсон цог чимэглэлүүдээс нэлээд онцгой ур хийцтэй нэгэн чимэглэл бол Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Баянголын амны булшнаас гарсан хүрэл чимэглэл юм (*Зураг 5*). Энэхүү чимэглэлийг хийхдээ хүрлийг нарийн давтаж цувьж, түүнийгээ хуйлан, олон навчин болон дугуй хэлбэртэй болгон, мод ургамлын дүрс гарган хийсэн бөгөөд үнэхээр уран нарийн хийцтэй ажээ. Өмнө бид богтагны оройд жинхэнэ ургамал, эсвэл ургамлын дүрс үйлдэж чимэглэдэг байсныг дурдсан билээ. Ургамлын дүрс бол богтаг малгайн чимэглэлийн нэлээд нийтлэг дүрслэл болдог байжээ. Ялангуяа богтагны нүүрэн талд цэцэг, ургамлын дүрстэй чимэглэл олон байдаг. Юань гүрний Чаби хатны өмссөн богтаг малгайн нүүрэн талын чимэглэл бусдаасаа онцгой, нүүрэн талын дээд хэсэгт цог чимэггүй дээрээсээ доош хүртэл таван дэлбээтэй цэцэг, навчийг эгнүүлэн хатгамаллан оёж, дээр нь сувднууд хадаж тогтоожээ. Ямандагийн мандал торгон нэхмэл зурган дээрх Тугтөмөр хаан, түүний ах Хошила нарын хатад болох Будшир, Бабуша нарын малгайн нүүрэн тал мөн ийм чимэглэлтэй.

#### Малгайн ар талын чимэглэл

XIII-XIV зууны уран зургуудад ихэнхдээ хүмүүсийг дүрслэхдээ толгойг үл ялиг хажуу байдлаас буюу дөрөвний гурав нь үзэгч рүү хандсан байдлаар зурдаг байсан тул малгайн ард талыг дүрсэлсэн зураг бараг байдаггүй. Тиймээс ар талыг хэрхэн чимэглэдэг байсныг биетээр олдсон малгайнаас л судлах боломж байна. Богтаг малгайн урд, ард аль ч чимэглэл ерөнхийдөө оёдолтой хэсгүүд дээр тэдгээрийг дарж халхалсан байдлаар байрласан байдаг. Ихэнхдээ богтаг малгайн бортого хэсгийг бүрсэн даавуу торгоны нийлэх залгаас хэсэг ардаа байх бөгөөд түүнийг сувд, сувс, явуу, хүрэл зэрэг төрөл бүрийн чимэглэлүүдээр чимдэг байв.

Эрмитажид хадгалагдаж буй монгол хатны богтаг малгайн арын оёдлыг дарж, сувд хэлхэж, маш гоёмсогор чимсэн байв. Түүний дээр урд талын дээд хэсэгт тогтоосонтой адил хонгио хөндлөн хадаж тогтоожээ.

#### Богтагны доод хэсгийн чимэглэл

##### Цог чимэг

Юань улсын хатдын хөрөг зурагт богтагны нүүрэн талын доод хэсэгт буюу толгойг боосон алчуурын завсарт гурван өөр янзын хэлбэр хийцтэй цог чимэглэлийг хавчуулан тогтоожээ (*Зураг 6*). Хамгийн олон удаа дүрслэгдсэн нь чандмань хэлбэрийн цог чимэг. Ийм чимэглэлүүд Ставрополь мужийн Киевское тосгоны ойролцоо Юн-Бабагийн толгодоос, Селитрэнни сууринаас, Дархан-Уул аймгийн Хонгор сумын Буурал уулын 2-р булшнаас гарчээ. Чандмань хэмээх нь “сэтгэлчлэнгийн эрдэнэ” зүрхэн эрдэнэ буюу “хүслийг хангагч эрдэнэ” гэсэн Уйгар, Согдоор дамжмал самгарди хэлний гаралтай үг (Дулам, 2011, 72). Тэгвэл тус чандмань хэлбэрийн цог чимгийг эзнийгээ өвчин зовлон, зуурдын үхлээс хамгаалах, хүслийг биелүүлэх увдистай хэмээн бэлгэдэн малгайн нүүрэн талд чимэглэн хаддаг

байжээ (Нандин-Эрдэнэ, Амарболд, 2022, 152). Хоёр дахь нь галын дөл хэлбэртэй эрдэнийг чулуун шигтгээтэй чимэглэлийг Содбал хааны хатан, Аюурбарбад Буянт хааны хатны богтаг дээр дүрсэлжээ. Үүнтэй төстэй чимэглэл Сүхбаатар аймгийн Асгат сумын Шарга уулын 2-р булшнаас, Онгон сумын Таван толгойн 5-р булш, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Аохань хошуунаас олодог байв. Галын дөл буюу асаж буй галаар ялалт их хүч чадлыг бэлгэддэг (Бадамхатан, 1987, 236). Гурав дахь хэлбэр нь Чаби хатан, Дармашир хатан, нэр нь үл мэдэгдэх нэгэн хатны богтаг малгайнд сувдаар хэлхэж хийсэн чимэглэл байна. Энэ дундаас Дармашир хатны чимэглэлийн сувдуудыг цайвар ногоондуу өнгийн торго, бөс эсвэл үйсэн дээр хадаж тогтоосон нь харагдаж байна. Персийн миниатюр зургуудад цог чимэг дүрслэгдсэн нь цөөхөн. Парисын номын санд хадгалагдаж буй Ордны ёслолыг харуулсан нэгэн миниатюр зурагт сувд шигтгэсэн цог чимэгтэй богтаг малгайтай хатдыг дүрсэлсэн боловч хэлбэр хийц нь сайн танигдахгүй байна. Монголын нууц товчооны 115-р зүйлд гарч буй “цогтой эм” хэмээх үгийг Германы эрдэмтэн Эрих Хэйниш “богтаг малгайтай эм” гэж орчуулсан байдаг (Эрдэнэбат 2010, 88). Хэрэв түүний таамаглал зөв бол цог чимэг нь богтаг малгайн хамгийн гол чимэглэл нь байсан байна.

#### Титэм чимэг

Богтаг малгайн өөр нэгэн гоёмсог чимэглэл нь титэм чимэглэл юм. Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойн 5-р булшнаас нүүрэн талдаа уран гоёмсог хээ угалзтай гуулин ялтсыг хавтгайлан давтаж нуман хэлбэрт оруулан алтаар шарсан богтаг малгайн цохонд хадаж тогтоох титэм маягийн чимэглэл олдсон бөгөөд үүнтэй төстэй чимэглэл Кудыргэгийн 17-р булш, Тэнгэр уулын өвөр, ОХУ-ын Алтай мужийн Усть-Алейка-5 гэдэг газар малтан шинжилсэн булшнуудаас гарчээ (Эрдэнэбат, 2010, 81-82). Мөн Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Доод Цахир хэмээх газраас цэцгэн хээтэй, гоёмсог хийцтэй мөнгөн титэм чимэг гарсан нь Чингис хаан музейд хадгалагдаж байна.

#### Сүйхэлжин чимэг

Богтаг малгайн доод хэсгүүдээс хамгийн баялаг чимэглэлтэй нь эрүүн доогуур уяж тогтоодог бүч юм. Үүнийг сүйхэлжин хэлбэртэй зүйлсээр чимнэ. Юань гүрний хатдын хөргүүдэд энэ чимэглэл нь бүгд адил сувд хэлхэж, сүйхэлжин хэлбэр гарган чимэглэсэн байдаг. Топкапи ордны цуглуулгад хадгалагдаж буй ордны ёслолыг харуулсан нэгэн зураг (Зураг 7) дахь хатдын сүйхэлжин чимэглэл Юань гүрний хатдынхтай яг ижилхэн дүрслэгджээ. Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Ямаат уулын булшнаас үзүүрт нь үйсээр хийж, бөсөөр бүрсэн сүйхэлжин унжлага чимэглэл хадсан бүч, мөн үйсээр хийж, бөсөөр бүрсэн хоёр ширхэг сүйхэлжин чимэглэл (Баярсайхан, Түвшинжаргал. 2016, 115), Гозгор толгойн хадны оршуулгаас ширэн дээр торгон утсаар том жижиг олон сувдыг хэлхэж хийсэн сүйхэлжин чимэглэл (Эрдэнэбат, 2014, 350), Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ухаа худагийн 65-р булшнаас сүйхэлжин хэлбэртэй, захаараа оёдлын нүхний оромтой ширэн эдлэлүүд тус тус гарчээ. Түүнчлэн хөрөнгө чинээ тааруу эмэгтэйчүүд нь хүрэл, гууль зэргийг нүхэлж хийсэн сүйхэлжин чимэглэлүүд хэрэглэж байсан ба ийм хүрэл чимэглэл Чингис хаан музейд хэд хэдэн ширхэг хадгалагдаж байна.

Эдгээрээс үзвэл, зэрэг зиндаа, хөрөнгө чинээнээс хамаарч энэ чимэглэл нь сувд, үйс, даавуу, шир, хүрэл гэх мэт олон янзын материалаар янз бүрийн байдлаар үйлдсэн ч үндсэн сүйхэлжин хэлбэрээ алдахгүй байна. Сүйхэлжин дүрс нь эм үүтгэлийг төлөөлөх бөгөөд эхнэр хүний гол чимэглэлийн дүрс юм. Х.Нямбуу “Авгай хүний эрхэм дээд эдлэлийг сүйх гэнэ. Энэ чимэглэл авгай хүний төрийн эдлэл хэмээгдэх бөгөөд эхнэр болгосны баталгаа ажээ” хэмээн өгүүлсэн байдаг (Нямбуу, 1968, 37). Харин богтаг малгайн шилэвчийг төдийлөн чимэглэдэггүй байсан бололтой. Энэ бүгдээс дүгнэж үзэхэд; дундад зууны монгол эмэгтэйн булш оршуулгаас богтаг малгайн үлдэгдлийн хамт тусгайлсан үйс, мод, ширээр хэлбэр гарган урлаж, гадуур нь бөс торгоор өнгөлж, дээр нь шил, сувс хэлхэж гоёсон энгийн чимэглэлээс авхуулаад уран нарийн хийцтэй, алт мөнгөн утсаар сүлжиж хийсэн, эрдэнийн чулуу шигтгэж урласан гоёмсог чимэглэл, брахми “ом” үсэгтэй цохимол буюу хөөмөл зэс чимэглэл, хүрэл хонгио, цэцгэн хэлбэртэй шилэн сувс зүүлт зэрэг олдворууд олон гарсан нь (Эрдэнэбат 2010, 81) зургийн сурвалжуудад дүрслэгдсэн баримтуудаар зарим нь нотлогдож байна.

Малгайн чимэглэлийн материал нь зэрэг зиндаа хөрөнгө чинээнээс хамаарч байсан. Ерөнхийдөө энэ үеийн зургийн сурвалжуудад ихэнхдээ хатад, язгууртан эмэгтэйчүүдийг дүрсэлсэн байх тул тэдний малгайн чимэглэлүүд нь алт, мөнгө, эрдэнийн чулуу байх нь олон байна. Тэр дундаа сувдан чимэглэл их олон дүрслэгджээ. Богтаг малгайн чимэглэлд сувдыг ашиглах нь нэлээд түгээмэл байжээ. Сувдан чимэглэлүүд Юань гүрний хатдын хөрөгт маш тодорхой дүрслэгдсэн байдаг. Харин Персийн миниатюр зургуудад Юань гүрний хатдын хөргүүд шиг богтаг малгайн чимэглэлүүд нарийн тодорхой дүрслэгдээгүй ч сувдан чимэглэлүүд малгайн дөрвөлжилсөн орой хэсгийн урд, ард талд, толгойд өмсөх хэсгийн ирмэг хүрээгээр, хажуу талд, цохон дээр байгаагаар нэлээд тодорхой дүрслэгдсэн байдаг. Ил хаант улсын хатдын богтагны гол чимэглэл нь сувд байхаас ч аргагүй юм. Персийн булан бол сувд олборлодог хамгийн гол газар. Ил хаант улс, Юань гүрний хооронд худалдаа арилжаа хамгийн их эргэлттэй байсан тул Юань гүрний хатдын гоёл чимэглэлд өргөн хэрэглэгдэх болжээ. Тиймээс бэлгэдлийн утга гэхээсээ илүүтэйгээр баян тансаг байдал, гоё сайхны илэрхийлэл байсан. Энэ талаар Эйрен Шеа: “Богтаг малгайн үнэт гоёл чимэглэл нь зөвхөн гоо үзэсгэлэн, өмссөн хүний хэргэм зэрэг, эд баялгийг харуулах зорилгоор ашиглагдаж байсан төдийгүй монголын эзэнт гүрний хүртээмжийг илтгэдэг байв. Хятад дахь монголчуудын ордонд ирж байсан сувд нь Персийн булан, магадгүй Коромандел эргээс<sup>1</sup> ирсэн байх нь дамжиггүй. Сувдыг перс хэлээр ярьдаг худалдаачид импортолдог байсан бол Карнелиан<sup>2</sup> одоогийн Бенгалийн бүс нутгаас ирсэн байх магадлалтай. Эдгээр чулууг ордны дээл болон богтаг малгайд ашигласан нь байлдан дагуулалт, худалдааны замаар Монголын эзэнт гүрний баялаг, цар хүрээг биечлэн харуулах нэг арга байсан” гэжээ (Eiren Shea, 2022).

Энэхүү судалгааны ажлын хүрээнд цаашид гүнзгийрүүлэн судлуулж дараах асуудал байгааг онцлон тэмдэглэж байна. Өнөөг хүртэл богтагны орой дээр голдуу

<sup>1</sup> Энэтхэгийн зүүн өмнөд хэсэг

<sup>2</sup> Ихэвчлэн хагас үнэт эрдэнийн чулуу болгон ашигладаг хүрэн улаан эрдэс

өд хатгадаг хэмээн ерөнхийлөн үздэг байсан бол судалгааны явцад илүү олон төрлийн зүйл малгайн оройд хатгадаг байсан нь илэрхий болж байна. Тиймээс Дийц цомог дахь Судрын чуулганы зургуудад дүрслэгдсэн оройн болон дээд ирмэг хэсэгт дүрсэлсэн дугариг<sup>3</sup>, Парисын үндэсний номын санд байгаа цомгийн зарим зургууд дахь оройн чимэглэл зэрэг өвөрмөц сонин эргэлзээтэй байгаа чимэглэлийн дүрслэлийг чухам юу болох, түүний утга бэлгэдлийг нарийвчлан судлууштай.

### Дүгнэлт

Богтаг малгайн хэлбэр хийц, чимэглэл нь нийгмийн байдлыг даган цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдсөөр маш олон янзын хэлбэр хийц, хээ, өнгө, дизайнтай болсоор байжээ. Үүний нэг илрэл нь Юань улс буддын шашныг төрийн шашин болгосноор “ом” үсэг, элдэв-очир зэрэг буддын шашны холбогдолтой үсэг, хээг богтаг малгайн чимэглэлд дүрслэх болсон явдал юм. Мөн Юань гүрэн болон Ил хаант улсын үед бүтээгдсэн Дийц, Сарай цомгийн уран зургууд дахь богтаг малгай нь хэлбэр хийц, чимэглэлийн хувьд хоорондоо илүү ижил төстэй байхад арай хожуу буюу XV зууны үед бүтээгдсэн гэж үздэг Парисын номын сан дахь зургууд дээрх богтаг малгайн толгойд өмсөх хэсэг олон янзын өнгөтэй, урд тал бага зэрэг дэрвийсэн, орой нь намхан, оройн чимгээс өөр чимэглэлгүй дүрслэгджээ. Түүнчлэн биетээр олдсон богтаг малгайнууд болон тэдгээрийн чимэглэлүүдээс Юань гүрний үед хамаарах нь илүү тансаг, чамин байгаа нь ажиглагдаж байна. Эндээс үзвэл, богтаг малгайн ур хийц, чимэглэл Юань гүрний үед хөгжлийнхөө оргил үед хүрсэн бололтой.

Богтаг малгайн чимэглэл нь зэрэг зиндаа хөрөнгө чинээнээс хамаарч харилцан адилгүй байсан ч чимэглэх ерөнхий зарчим, утга бэлгэдэл нь ижилхэн байжээ.

Чимэглэлүүдийн хэлбэр хийц, хээ угалз, үсэг бичээс болон тэдгээрийг үйлдсэн материал нь ховор үнэт чулуунаас эхлээд даавуу, шир, мод зэрэг энгийн олдоцтой зүйлсээр ч хийсэн байгаа нь богтаг малгайн чимэглэл нь өмссөн эзнийхээ байр суурь, зэрэг зиндаа, хөрөнгө чинээ, шашин шүтлэг зэрэг олон зүйлийг илтгэн харуулдаг байжээ. Нөгөө талаар богтаг малгайг хийх тансаг торго бөс, малгайн чимэглэлийг урлаж байсан үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрийг хийж гүйцэтгэсэн уран тансаг ур хийцээс харахад тухайн цагийн Монголчууд эд баялаг, урлаг, оюуны санааны өндөр түвшинд хүрснийг илтгэхийн зэрэгцээ Монголын эзэнт гүрний эд баялаг, цар хүрээг харуулж байжээ.

### Ашигласан материалын жагсаалт

1. Бадамхатан, С. 1987. *БНМАУ-ын Угсаатны зүй. 1-р боть*. Улаанбаатар, Монгол улс: Улсын хэвлэлийн газар.
2. Бат-Ирээдүй, Ж., Арьяасүрэн, Ч. 1999. *Монгол ёс заншлын их тайлбар толь*. Улаанбаатар, Монгол улс: Адмон.
3. Батсайхан, З. 1995. *Монгол эхнэрийн богтаг малгай*. Улаанбаатар, Монгол улс.

<sup>3</sup> Миний үзэж буйгаар нар сарыг бэлгэдсэн чимэглэл

4. Баяр, Д. 2002. *Монголчуудын чулуун хэрэг*. Улаанбаатар, Монгол улс.
5. Баясах, Ж. 2005. *Их Монгол улсын түүхэнд холбогдох Хятад хоёр сурвалж бичиг*. Улаанбаатар, Монгол улс.
6. Бира, Ш., Дашцэдэн, Т., Сумъяабаатар, Б. ба бус. 2011. *Монголын нууц товчоо. Сонгомол эх*. Улаанбаатар, Монгол улс: Мөнхийн үсэг.
7. Гильом де Рубрук. 1988. *Дорно этгээдэд зорчсон минь*. Улаанбаатар, Монгол улс: Улсын хэвлэлийн газар.
8. Дулам, С. 2009. “Монгол малгай-бэлгэдлийн цогцлол.” *Нүүдэлчдийн өв судлал. Tomus IX*: 98-113.
9. Дулам, С. 2011. *Монгол бэлгэдэл зүй. Дүрсийн бэлгэдэл зүй. Дохио зангааны бэлгэдэл зүй*. Улаанбаатар, Монгол улс: Битпресс.
10. Жиованни дель Пано Карпини. 1988. *Монголчуудын түүх*. Улаанбаатар, Монгол улс: Улсын хэвлэлийн газар.
11. Илдико Ока. 2015. “Mongol clothing in the Yuan period.” *Acta orientalia academiae scientiarum Hungaricae*. Vol. 68, No.4: 385-414.
12. Марта Бойер. 1995. *Mongol jewelry*.
13. Мункуев, Н.Ц. 2014. *Монгол татаарын бүрэн тодорхойлолт*. Улаанбаатар, Монгол улс: Мөнсудар.
14. Нямбуу, Х. 2002. *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар, Монгол улс.
15. Нямбуу, Х. 1968. “Халхын зарим нутгийн хээ угалзын зүйлээс. /XIX-XX зууны эхэн/.” *Studia Ethnographica*, Tom. III.
16. Нямбуу, Х. 1991. *Хамгийн эрхэм ёсон*. Улаанбаатар, Монгол улс: Сүүлэнхүү хүүхдийн хэвлэлийн газар.
17. Сайхансүвд, Д. 2018. “Юань гүрний үеийн монгол хатдын хөрөг зургийн дүрийн онцлог.” *Монголын соёл урлаг судлал. Tomus XXVII*: 226-232.
18. Сувд, Б., Эрдэнэбат, У., Саруул, А. 2015. *Монгол хувцасны нууц товчоо II*. Улаанбаатар, Монгол улс.
19. Эрдэнэбат, У. 2006. *Монгол эхнэрийн богтаг малгай*. Улаанбаатар, Монгол улс: Мөнхийн үсэг.
20. Эрдэнэбат, У. 2010. “Богтаг малгайн чимэглэл.” *Оюуны хэлхээ*. 2010. I. (06): 71-113.

## Цахим өгүүлэл

1. Ayrat G. Sitdikov, Lyudmila E. Maklasova. 2017. "Male Feathered Headwear of 13th-14th Centuries." *European Research Studies Journal* Volume XX, 2017 - Special Issue: 352-361. [https://www.um.edu.mt/library/oar/bitstream/123456789/34594/1/Male\\_Feathered\\_Headwear\\_of\\_13th\\_14th\\_Centuries\\_2017.pdf](https://www.um.edu.mt/library/oar/bitstream/123456789/34594/1/Male_Feathered_Headwear_of_13th_14th_Centuries_2017.pdf)
2. Баярсайхан, Э., Түвшинжаргал, Т. 2016. "Агуйт цахир уулын Ямаатын агуйн оршуулга." *Музей судлал*, Tomus XVII: 113-124. <https://www.academia.edu/44790934>
3. Нандин-Эрдэнэ, Н., Амарболд, Э. 2022. "Богтаг малтайн нэгэн цогчимгийн тухай." *Studia archaeologica*, Tomus XLI: 148-157. doi.org/10.5564/sa.v41i1.2490
4. Хүрэлсүх, С., Амгалантөгс, Ц., Фрохлич, Б. 2011. "Баянхонгор аймгаас олдсон хадны оршуулгууд." *Studia archaeologica*, Tomus XXX: 237-246. <https://www.yumpu.com/xx/document/read/56588365/arch-sudlal-2011>
5. Эрдэнэбат, У., Хүрэлсүх, С. 2007. "Нартын хадны оршуулга." *Studia Archaeologica*, Tom. (IV) XXIV: 332-359. [https://www.academia.edu/11765714/The\\_Cave\\_Burial\\_from\\_Nartiin\\_Khad\\_Mongolia](https://www.academia.edu/11765714/The_Cave_Burial_from_Nartiin_Khad_Mongolia)
6. Эрдэнэбат, У. 2010. "Богтаг малгайн чимэглэл." *Оюуны хэлхээ*. I, (06): 71-113. <https://www.academia.edu/23717679>
7. Эрдэнэбат, У. 2014. "Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Дунд нурууны хадны оршуулгын дурсгалууд." *Археологийн судлал*, Tomus XXXIV: 344-365. <https://www.yumpu.com/xx/embed/view/UvbSmHutLwpzdoWR>

## Цахим эх сурвалж

1. Танхай банди буюу комиксчин Бадарчин. 2022. 2019 онд Казаньд гарсан үзэсгэлэнгийн каталоги. 2023.04.03. <https://twitter.com/Gonchig13/status/1510545326192861188/photo/3>
2. Eiren Shea. 2022. "Portrait of Chabi". [smarthistory.org](https://smarthistory.org). 2022.07.15 <https://smarthistory.org/portrait-of-chabi/>

### Хавсралт зураг



**Зураг 1.** Ордны ёслол. Зургийн хэсэг. Рашид ад Дин судрын чуулганы чимэглэл зураг. Тавриз (?), XIV зууны 1-р хагас. Усан будаг, цаас. Хэмжээ: 36.1 см х 29.8 см.<sup>4</sup>



**Зураг 2.** Абага хаан хатны хамт. Зургийн хэсэг. XV зуун.<sup>5</sup>



**Зураг 3.** Хүлэгү хаан Докуз хатан. Зургийн хэсэг. XIV зуун. Рашид ад Дин судрын чуулганы чимэглэл зураг. XIV зуун.<sup>6</sup>

<sup>4</sup> Берлин, Штаатс номын сан Дийц цомог Diez A fol. 70, p. 10  
[https://upload.wikimedia.org/wikipedia/commons/f/f6/DiezAlbumsEnthronization\\_b.jpg](https://upload.wikimedia.org/wikipedia/commons/f/f6/DiezAlbumsEnthronization_b.jpg)

<sup>5</sup> Парисын Үндэсний номын сан Supplement Persan 1113 fol. 194r. 1430  
<https://portail.bibliothecafr/ark:/43093/1fdatal1e3e9f1de2e959deba28259231ab6d3e85eeee9d>

<sup>6</sup> Парисын Үндэсний номын сан Supplement Persan 1113 fol. 174v.  
[https://en.wikipedia.org/wiki/Doquz\\_Khatun#/media/File:HulaguAndDokuzKathun.JPG](https://en.wikipedia.org/wiki/Doquz_Khatun#/media/File:HulaguAndDokuzKathun.JPG)



Зураг 4. Чо О Сүн.<sup>7</sup>



Зураг 5. Богтаг малгайн оройн хүрэл чимэг. Булган аймаг,  
Хутаг-Өндөр сум, Баянголын амны 4-р були.<sup>8</sup>



Зураг 6. Раднашир хатан.  
Тайванийн үндэсний ордон музей.  
Хэмжээ: 61.2 см х 47.7 см.<sup>9</sup>



Зураг 7. Монгол хаан эхнэрийн хамт хаан ширээнд.  
Зургийн хэсэг. Рашид ад Дин. Судрын чуулганы  
чимэглэл зураг.<sup>10</sup>

<sup>7</sup> Эрдэнэбат, У. 2006. Монгол эхнэрийн богтаг малгай ном.  
<sup>8</sup> <https://twitter.com/nochiroo/status/711870714005970944/photo/2>

<sup>9</sup> <https://www.pinterest.com/pin/492792384217936497/>

<sup>10</sup> Табриз. Топкапи ордон музей. 1330 fol.23a  
<https://richardcullinan.wordpress.com/2016/08/26/recreating-the-costume-of-medieval-persia>